



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,
Булган аймаг	тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
2023 он	Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
	Аудитын менежер: Ж.Энхцоодол
	Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
	Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу,

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	8

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг. 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

*А.О.О.* № *42*

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХАНГАЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА  
Л.САЙНГЭРЭЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хангал сумын ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 101.2 хувиар өссөн байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” ОУ-ын стандартыг “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хангах, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” бодлогыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласан байна.

006020092

### **Бусад мэдээлэл**

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 үндсэн зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 99.5 хувиар үнэлэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

		/төгрөгөөр/	
Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.	
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
Эргэлтийн хөрөнгийн дүн	194,405,192.5	182,680,359.2	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,099,745,664.7	1,922,741,876.6	
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,294,150,857.1</b>	<b>2,105,422,235.9</b>	
Нийт өр төлбөрийн дүн	1,121,750.0	-	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,293,029,107.1	2,105,422,235.9	
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,294,150,857.1</b>	<b>2,105,422,235.9</b>	
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
Үйл ажиллагааны орлогын дүн	748,163,427.7	1,845,370,741.9	
Үйл ажиллагааны зардлын дүн	781,960,329.1	1,033,939,613.1	
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(33,796,901.4)</b>	<b>811,431,128.7</b>	
Үйл ажиллагааны бус үр дүн	16,021,935.7	2,544,000.0	
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(44,046,837.1)</b>	<b>812,393,128.7</b>	
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,293,029,107.1	1,293,029,107.1	
Тайлант оны үр дүн	-	812,393,128.7	
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,293,029,107.1</b>	<b>2,105,422,235.9</b>	
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	748,163,427.7	931,774,093.9	
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	537,133,964.7	887,994,093.9	
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>211,029,463.0</b>	<b>43,780,000.0</b>	
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(211,559,463.0)</b>	<b>(43,780,000.0)</b>	
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>	
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(530,000.0)</b>	<b>0.0</b>	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>558,411,152.2</b>	<b>874,762,614.9</b>	
Урсгал зардал	512,969,752.2	852,262,614.9	
Хөрөнгийн зардал	45,441,400.0	22,500,000.0	
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>558,410,205.7</b>	<b>874,396,614.9</b>	
Улсын төсвөөс санхүүжих	-	-	
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	558,410,205.7	874,396,614.9	

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 837,153.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 837,153.6 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Байгууллагын эзэмшилд байгаа 25 нэгж талбарын нийт 837,153.6 мянган төгрөгийн суурь үнэлгээ бүхий газрыг санхүүгийн бүртгэл тайланд тусгаагүй алдаа нь УСНББОУС-17, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа дээрх алдааг залруулсан.

Аудитаар нийт 687,706.9 төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,428.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 686,278.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлжсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,449.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,496.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### **3.1 Төлбөрийн акт**

1. Шатахууны зардлыг олгохдоо нийт 337.5 мянган төгрөгийг илүү тооцон олгож Төсвийн тухай хуулийн 5.1.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.4, 20.2.4 -д заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Хүндэтгэлийн арга хэмжээнд зориулан 639.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### **3.2 Албан шаардлага**

1. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 удаагийн орлогын нийт 662,795.2, төсөв хөрөнгө зарцуулах 2 удаагийн 9,616.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан заалттай нийцээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 2,021.2 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1-2.1.6, 5.2 дахь заалттай нийцээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ-ын эзэмшилд байгаа 25 нэгж талбарын нийт 837,153.6 мянган төгрөгийн суурь үнэлгээ бүхий газрыг санхүүгийн бүртгэл тайланд тусгаагүй.	1	837,153.6	1	837,153.6			1	837,153.6				
Дүн	1	837,153.6	1	837,153.6	-	-	1	837,153.6	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зардлыг илүү тооцон олгосон.	1	377.5	1.0	377.5								
Албан бус ажил буюу золголтоор явахад томилолтын зардал олгосон.	1	412.0	1.0	412.0								
Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох журмыг баримтлаагүй зориулалт бус зарцуулсан.	1	2021.2			1.0	2021.2						
Дүн	4	3449.7	3.0	1428.5	1.0	2021.2	0	0	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим хуудсанд нийт 29 удаагийн 9,616.8 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах шийдвэр, 22 удаагийн нийт 662,795.5 мянган төгрөгийн таван сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй.	1	672412.2			1	672,412.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>672412.2</b>			<b>1</b>	<b>672,412.2</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин нийт 11845.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	11,845.0			1	11,845.0		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин бэлэг дурсгалын зүйл, хүнс худалдан авсан	1	639.0	1	639.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>12,484.0</b>	<b>1</b>	<b>639.0</b>	<b>1</b>	<b>11,845.0</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>684896.2</b>	<b>1</b>	<b>639.0</b>	<b>2</b>	<b>684257.2</b>	<b>0</b>	<b>0</b>